



2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Монгол Улсын иргэн нь “хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах”, мөн тус зүйлийн 6 дах хэсэгт иргэн нь “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэж зааж өгсөн байдаг. Үндсэн хуулийн дээрх зохицуулалтууд нь эрүүл мэндийн салбарт ажиллаж буй иргэдийн эрхийг зайлшгүй хамгаалах үндэслэл болно. Тодруулбал, эрүүл мэндийн салбарын ажилтнууд нь иргэнийхээ хувиар хөдөлмөрийн аятай таатай нөхцөлөөр хангуулах эрхтэй байхын зэрэгцээ тус салбараас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч буй нийт иргэдийн эрүүл байх эрхийг хамгаалах хүрээнд төрөөс тус салбарт ажиллагсдын эрхийг хангах бодлого боловсруулах суурь үндэслэл болж байна.

Үүний дагуу Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2.4-т эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтыг дэвшүүлж, хүний нөөцийн тогтвортой байдлыг улс орны хөгжлийн стратегийн нэг тулгуур зорилт болгон тодорхойлсон.

Энэхүү бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “Алсын хараа 2050” бодлогын зорилт 2.2-ыг 2021–2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.29-д хүн амын хэрэгцээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалттай уялдуулан хүний нөөцийг бэлтгэх, орон нутгийн хэрэгцээг хангах, эмч, эмнэлгийн ажилтны цалин

хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, бодит цалингийн хэмжээг улсын дунджаас дээш байлгах арга хэмжээг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.4.1-т “Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх зорилгоор шинэ, дэвшилтэт технологи, арга, аргачлал нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, гадаадын ур чадвар бүхий мэргэжлийн багийг эх орондоо урьж, туршлага солилцуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ”, 2.3.4.2-т “Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллах эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сувилагчийг түлхүү бэлтгэнэ”, 2.3.4.3-т “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, алслагдсан орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшууллыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан..

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “Эмнэлгийн мэргэжилтний тухай” анхдагч хуулийн төслийг 2025 онд боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан нь салбарын эрх зүйн зохицуулалтыг бие даасан, цогц байдлаар шинэчлэх бодит шаардлага үүссэнийг харуулж байна.

Эдгээр урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлийн баримт бичгүүд нь эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг тусгайлсан бие даасан хуулиар зохицуулах, тэдний эрх, үүрэг, нийгмийн баталгаа, аюулгүй байдал, мэргэжлийн ёс зүй, хариуцлага, мэргэжлийн эрсдэлийн даатгалын эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлэх хууль зүйн үндэслэл болж байна.

Иймд эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгааг бодитой хангах, салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг дээшлүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн ажилтны тухай” бие даасан хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл бүрджээ.

1.2.Практик шаардлага

Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд 4,914 гаруй эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж, нийт 69.7 мянган эрүүл мэндийн ажилтан хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд ажиллаж байна. Манай улсын хувьд 10,000 хүн амд ногдох их эмчийн тоо 44.3 байгаа нь дэлхийн дунджаас 2.6 дахин, Номхон далайн баруун бүс нутгийн орнуудаас 1.9 дахин өндөр үзүүлэлт боловч энэ нь хүний нөөцийн жигд хуваарилалт, хүртээмжийг бүрэн хангаж чадсан гэсэн үг биш юм.

Тодруулбал, хөдөө орон нутаг, сум, сум дундын эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн дутагдал байсаар байгаа бөгөөд нийт эрүүл мэндийн ажилтны 41.5 хувь нь хөдөө орон нутаг, алслагдсан сум, багт ажиллаж байгаа бол үлдсэн хувь нь Улаанбаатар хотод төвлөрсөн нь хот, хөдөөгийн хооронд хүний нөөцийн тэнцвэргүй байдлыг бий болгож байна. Энэ нөхцөл байдал нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид бодит сөрөг нөлөө үзүүлж байна.

2023 онд хийгдсэн “Эрүүл мэндийн ажилтнуудын нийгмийн баталгааны суурь судалгаа”-аар эрүүл мэндийн ажилтнуудын бодит орлого хангалтгүй байгааг тогтоосон бөгөөд судалгаанд оролцсон таван хүн тутмын нэг нь хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой байна. Мөн судалгаанд оролцогчдын 89.2 хувь нь банк болон банк бус санхүүгийн байгууллагад дунджаар хоёр төрлийн зээлтэй байгаа нь санхүүгийн эмзэг байдал өндөр байгааг харуулж байна.

Үүнээс гадна судалгаанд оролцсон эрүүл мэндийн ажилтнуудын 44.1 хувь нь бага насны хүүхэдтэй, 46.9 хувь нь галлагаатай орон сууцанд амьдарч байгаа нь орон сууц, нийгмийн дэд бүтцийн баталгаа хангалтгүй байгааг илтгэнэ. Эрс тэс уур амьсгал, өргөн уудам нутаг дэвсгэр, хүн амын нягтаршил багатай, дэд бүтэц сул хөгжсөн, хот, хөдөөгийн ялгаатай байдал зэрэг Монгол Улсын онцлог нөхцөлтэй уялдуулан авч үзвэл эрүүл мэндийн ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг хангах одоогийн эрх зүйн зохицуулалт бодит хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна.

Түүнчлэн эмч, эрүүл мэндийн ажилтнууд үйлчлүүлэгчийн зүгээс ирэх гүтгэлэг, доромжлол, заналхийлэлд өртөх, нийгмийн сүлжээнд хууль бусаар дуу, дүрсний бичлэг нийтлэгдэх зэрэг зөрчил тасрахгүй байна. Хүний эрхийн үндэсний комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай 22 дахь илтгэл” (2023 он) тайланд дурдсанаар манай улсад гурван эмч, эмнэлгийн мэргэжилтэн тутмын хоёр нь

ямар нэг хэлбэрээр үйлчлүүлэгчийн дарамт, заналхийлэлд өртөж байгаа нь тэдний мэргэжлийн үйл ажиллагаа аюулгүй, тогтвортой явагдах нөхцөл хангагдаагүйг харуулж байна. Иймд эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн баталгааг бэхжүүлэхийн зэрэгцээ иргэн, үйлчлүүлэгчийн эрх, үүргийг тодорхой хуульчлах бодит шаардлага үүсэж байна.

Сүүлийн таван жилийн хугацаанд цагдаагийн байгууллагаас Эрүүгийн хуулийн 15.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжтэй үйлдлээр 149 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хэрэг үүсгэн шалгасан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн мэдээллээр 2021–2024 оны хооронд нийт 40 хэрэгт 83 эмч, мэргэжилтнийг холбогдуулан шүүхээр шийдвэрлэж, 44 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ял шийтгэл оногдуулсан байна.

Энэхүү нөхцөл байдал нь эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын ачаалал, үйлчлүүлэгчийн дарамт, шүүхийн маргаан, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрсдэлээс болгоомжлон мэргэжлийн үйл ажиллагаагаа гүйцэтгэхээс зайлсхийх, оношилгоо, эмчилгээний шийдвэр гаргахдаа хэт болгоомжлох байдалд хүргэж байна. Олон улсын судалгаанд үүнийг “хамгаалалтын анагаах ухаан” хэмээн тодорхойлдог бөгөөд ийм нөхцөлд өвчтөн шаардлагатай тусламж, үйлчилгээгээ цаг алдалгүй авах боломж хязгаарлагдаж, өвчин хүндрэх, эмчилгээний зардал нэмэгдэх сөрөг үр дагавар бий болдог.

Анагаахын шинжлэх ухаан нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг салбар бөгөөд эмнэлгийн мэргэжилтний хүчин чармайлтаас үл хамааран хүсээгүй үр дагавар гарах эрсдэл бодитоор оршсоор байна. Иймд санаатайгаар мэргэжлийн алдаа гаргаснаас бусад тохиолдолд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эрүүгийн хариуцлагад татах бус, мэргэжлийн хариуцлага, эрсдэлийн удирдлагын тогтолцоогоор зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Олон улсад эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрүүл мэндийн эрсдэлийн улмаас учирсан хохирлыг богино хугацаанд, шүүхийн маргаангүйгээр нөхөн төлүүлэх тогтолцоог хуульчлан хэрэгжүүлдэг бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээний алдаа, зөрчлийг бүртгэх, дүн шинжилгээ хийх тогтолцоог нэвтрүүлснээр эрсдэлийг нуун дарагдуулах бус, алдаанаасаа суралцаж, дахин давтагдахаас сэргийлэхэд чиглэсэн эрсдэлийн удирдлагын системийг бүрдүүлдэг.

Манай улсад эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн хариуцлагаас үүдэн эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсныг нотлох, хохирлын хэмжээг тогтоож шүүхээр шийдвэрлэх үйл явц удаан хугацаа шаарддаг бөгөөд энэ хугацаанд өвчтөний байдал хүндрэх, хохирлын хэмжээ нэмэгдэх эрсдэл өндөр байдаг. Иймд эмнэлгийн тусламж, үйлчилгээний эрсдлээс үүдэн гарсан гэм хорыг хохирол багатай даван туулах, өвчтөн болон эмнэлгийн мэргэжилтнийг аль алиныг хамгаалах даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх бодит хэрэгцээ бий болсон.

Дээрх бодит нөхцөл, судалгааны дүн, практикт тулгамдаж буй асуудлуудыг харгалзан үзэхэд эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг тусгайлсан бие даасан хуулиар цогцоор нь зохицуулах зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах үндсэн нөхцөл болно.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төсөл нь нийт 9 бүлэг, 88 зүйлтэй бөгөөд дараах үндсэн харилцааг цогцоор нь зохицуулж байна. Үүнд:

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэг “Нийтлэг үндэслэл”-д хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, эрүүл мэндийн ажилтны үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмыг тодорхойлсон. “Эрүүл мэндийн ажилтны тухай” хуулийн төсөл нь эрүүл мэндийн салбарт ажиллагсдын, ялангуяа эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй ажилтнуудын эрх зүйн байдлыг бие даасан байдлаар тодорхойлох, тэдний эрх, үүрэг, нийгмийн баталгааг хангах, мэргэжлийн үйл ажиллагааг саадгүй, аюулгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилготой юм.

Хоёрдугаар бүлэг “Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн удирдлага, ажиллах орчин”-д улсын болон орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн төлөвлөлт, зохион байгуулалт, тайлагнал, үнэлгээ, ажиллах орчны аюулгүй байдал, ажлын ачаалал, мэргэжлийн эрсдэлийн удирдлагатай холбогдох харилцааг зохицуулсан. Энэ нь хот, хөдөөгийн ялгаатай байдал, хүний нөөцийн тэнцвэргүй байдлыг бууруулахад чиглэж байна.

Гуравдугаар бүлэг “Эрүүл мэндийн ажилтанд холбогдох нийтлэг зохицуулалт”-д эрүүл мэндийн ажилтны нийтлэг эрх, үүрэг, нийгмийн баталгааны үндсэн зохицуулалтыг тусгасан. Үүнд цалин хөлс, урамшуулал, тогтвор суурьшлын дэмжлэг, эрүүл мэндийн үзлэг, амралт, гамшиг, онцгой нөхцөлд ажилласан тохиолдлын нөхөн олговортой холбогдох харилцаа хамаарна.

Дөрөвдүгээр бүлэг “Эмнэлгийн мэргэжилтэнд холбогдох зохицуулалт” нь хуулийн төслийн гол бүлэг бөгөөд эмчлэх, сувилах, эх барих, эм барих, сэргээн засах зэрэг мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаатай шууд холбоотой харилцааг зохицуулна. Энэ бүлэгт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шалгалт, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг, хариуцлага, төгсөлтийн дараах болон тасралтгүй сургалтын тогтолцоог тодорхойлсон.

Тавдугаар бүлэг “Эмнэлгийн бусад мэргэжилтний эрх зүйн байдал”-д эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа боловч эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэггүй бусад мэргэжилтний бүртгэл, эрх, үүрэг, дэмжлэг, хориглох үйл ажиллагааг зохицуулсан.

Зургаадугаар бүлэг “Эмнэлгийн мэргэжилтний холбоо”-д эмнэлгийн мэргэжилтний өөрөө удирдах байгууллагын эрх зүйн байдал, бүтэц, чиг үүрэг, санхүүжилт, ил тод байдал, мэргэжлийн ёс зүй, стандарт, тасралтгүй хөгжлийн асуудлыг зохицуулсан бөгөөд энэ бүлгийн зохицуулалтыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан.

Долоодугаар бүлэг “Мэргэжлийн хариуцлагын даатгал”-д эмнэлгийн тусламж, үйлчилгээний явцад учирч болзошгүй эрсдэлээс үүдэн гарсан гэм хорыг шуурхай, хохирол багатайгаар барагдуулах зорилгоор мэргэжлийн хариуцлагын даатгалын тогтолцоог хуульчилсан. Энэ бүлэг нь эмнэлгийн мэргэжилтэн болон үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг тэнцвэртэй хамгаалахад чиглэсэн бөгөөд мөн 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөхөөр тусгасан.

Наймдугаар бүлэг “Эмнэлгийн маргааныг шийдвэрлэх журам”-д эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаатай холбоотой гомдол, маргааныг шүүхийн болон шүүхийн бус журмаар шийдвэрлэх, мэргэжлийн дүгнэлт гаргах, өмгөөлүүлэх эрхийг хангах харилцааг зохицуулсан.

Есдүгээр бүлэг “Бусад зүйл”-д хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, шилжилтийн зохицуулалт, хууль хүчин төгөлдөр болох хугацаатай холбогдох зохицуулалтыг тусгасан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Эрүүл мэндийн ажилтны тухай хуулийн төсөл батлагдсанаар эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тогтвортой байдал, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд эерэг өөрчлөлт гарах үндэс бүрдэх боловч эдийн засаг, нийгэм, хууль зүйн тодорхой үр дагавар үүсэх магадлалтай байна.

Хуулийн төсөл хэрэгжсэнээр эрүүл мэндийн ажилтны цалин хөлс, урамшуулал, нийгмийн баталгаа, сургалт, ажлын байрны аюулгүй ажиллагаа, мэргэжлийн хариуцлагын даатгалтай холбоотой зардал улсын болон орон нутгийн төсөвт нэмэлт ачаалал үүсгэх нөхцөл бүрдэнэ. Ялангуяа алслагдсан болон хөдөө орон нутагт ажиллах нөхцөлийг дэмжих, тогтвор суурьшлын урамшуулал олгох, хамгаалах хэрэгсэл, сургалтын санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлага бодитоор тавигдана. Гэсэн хэдий ч эдгээр зардал нь урт хугацаанд эрүүл мэндийн ажилтны шилжилт хөдөлгөөн, ажлаас гаралтыг бууруулах, хүний нөөцийн тогтворгүй байдлаас үүдэх давхар зардлыг багасгах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний алдаа, маргаанаас шалтгаалах шүүхийн зардал, нөхөн төлбөрийг бууруулах замаар эдийн засгийн эерэг өгөөж бий болгох хандлагатай байна. Иймд эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулах зорилгоор хуулийн хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах, улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сан, олон улсын төсөл, хөтөлбөр, хувийн хэвшлийн оролцоог хослуулсан санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах, зардал–үр ашгийн дунд хугацааны тооцоолол хийж, хэрэгжилтийн явцад тогтмол үнэлгээ хийх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн энэхүү хуулийн төсөл батлагдсанаар эрүүл мэндийн ажилтны эрх зүйн хамгаалал сайжирч, ажлын аюулгүй орчин, нийгмийн баталгаа нэмэгдсэнээр тэдний мэргэжлийн үйл ажиллагаанд итгэх итгэл, сэтгэл ханамж дээшлэх эерэг үр нөлөө үзүүлнэ. Энэ нь эрүүл мэндийн салбарын нэр хүндийг өсгөх, залуу мэргэжилтнүүдийг салбарт татах, орон нутагт тогтвортой ажиллах сонирхлыг нэмэгдүүлэхэд чухал ач

холбогдолтой. Түүнчлэн иргэн, үйлчлүүлэгчийн эрх, үүргийг тодорхой хуульчилснаар эмнэлгийн мэргэжилтэн болон үйлчлүүлэгчийн харилцаанд харилцан хүндэтгэл, ойлголцол нэмэгдэж, зөрчил, үл ойлголцол буурах хүлээлттэй байна. Гэсэн хэдий ч хууль хэрэгжиж эхлэх эхний үед олон нийтийн дунд ойлголтын зөрүү, хүлээлтийн зөрчил үүсэх магадлалтай тул эрүүл мэндийн ажилтнууд болон иргэдэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, иргэн, үйлчлүүлэгчийн эрх, үүргийг энгийн, ойлгомжтой хэлбэрээр таниулах, гомдол, маргааныг шүүхийн бус журмаар эвлэрүүлэн шийдвэрлэх тогтолцоог бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Эрүүл мэндийн ажилтны тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний хөдөлмөрлөх эрх, аюулгүй, эрүүл орчинд ажиллах эрх, нийгмийн хамгаалалд хамрагдах эрх, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах үндсэн зарчимд нийцсэн бөгөөд эдгээр эрхийг эрүүл мэндийн салбарын онцлогт тохируулан бодитой хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Хуулийн төсөл нь эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг бие даасан байдлаар тодорхойлж, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах, нийгмийн баталгааг хангах замаар Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомжуудтай уялдуулах, зарим зохицуулалтыг нарийвчлах, давхардлыг арилгах хууль зүйн хэрэгцээ үүснэ. Тухайлбал, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиудад эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдал, мэргэжлийн үйл ажиллагаа, нийгмийн баталгаа, эрсдэлийн удирдлагатай холбоотой зохицуулалтыг нийцүүлэх зорилгоор зарим зохицуулалтыг хүчингүй болгох зэргээр нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Эдгээр өөрчлөлт нь хуулиудын хоорондын давхардал, зөрчлийг арилгаж, салбарын эрх зүйн зохицуулалтыг цогц, ойлгомжтой болгоход чиглэнэ.

Мөн энэхүү хуулийн төсөл нь эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой хариуцлага, маргаан шийдвэрлэх харилцаанд нөлөө үзүүлэх

тул Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагалдуулан боловсруулах шаардлага бий болно. Үүнд мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил, гэмт хэргийг ялган тодорхойлох, мэргэжлийн алдаа, эрсдэлийг зохистой журмаар шийдвэрлэх, эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн хамгаалалтыг хангахтай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгах асуудал хамаарна.

Түүнчлэн мэргэжлийн хариуцлагын даатгал, эмнэлгийн мэргэжилтний холбоо зэрэг шинэ институц, тогтолцоог бий болгохтой холбогдон хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дагалдах журам, заавар, стандартуудыг шинээр боловсруулах хэрэгцээ үүснэ. Эдгээр журам, зааврыг хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө үе шаттайгаар боловсруулж, батлах нь хуулийн хэрэгжилтийг тасралтгүй, ойлгомжтой, жигд хангах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Хуулийн хэрэгжилтийн эхний үед тайлбар, ойлголтын зөрүү, практикт хэрэгжүүлэх хүндрэл үүсэх эрсдэлтэй тул хэрэгжилтийн явцад тогтмол мониторинг хийх, илэрсэн асуудалд тайлбар, зөвлөмж гаргах, хууль хэрэглэгч байгууллага, албан тушаалтанд зориулсан нэгдсэн сургалт, арга зүйн зааварчилгаа зохион байгуулах шаардлагатай. Дээрх арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлснээр Эрүүл мэндийн ажилтны тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай уялдан хэрэгжиж, салбарын эрх зүйн зохицуулалтын тогтвортой байдал, хуулийн зорилго, хэрэгжилтийн үр нөлөөг бүрэн хангах боломж бүрдэнэ.

Эрүүл мэндийн ажилтны тухай хуулийн төслийг дагалдан боловсруулах хуулийн төсөл:

1. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
3. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай